



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/01/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг: Утас:261668 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер:Ц.Гүнжидмаа Утас:261885 Цахим хаяг:gunjidmaag@audit.gov.mn Ахлах аудитор:Б.Сэржмядаг Утас:261885 Цахим хаяг:serjmyadagb@audit.gov.mn Аудитор А.Даваадорж Утас:261885 Цахим хаяг:davaadorja@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.9.1 Мөнгөн хөрөнгө	8
2.9.2 Авлага.....	8
2.9.3 Урьдчилж гарсан зардал	9
2.9.4 Бараа материал	9
2.9.5 Үндсэн хөрөнгө	9
2.9.6 Өр төлбөр	10
2.9.7 Засгийн газрын хувь оролцоо.....	10
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.12. Шилэн дансны мэдээлэл	12
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3. Менежментийн захидал.....	13
3.1 авлага, өглөгийн данстай холбоотой асуудал.....	13
3.2 төсвийн зарцуулалттай холбоотой асуудал	14
3.3 төсвийн зарцуулалттай холбоотой асуудал	14
3.4 харьяа газуудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал.....	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	16
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	22
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.25 № 02/943
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Татварын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Татварын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0325SAG20.Docx

001051730

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Заяабал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, авлагыг барагдуулах, төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулах, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 05-наас 2020 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж, гэрээт аудитор Н.Нямсүрэн нар гүйцэтгэв.

Татварын ерөнхий газар 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/693 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд орших ба төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх, гэж тодорхойлсон байна.

Татварын ерөнхий газрын үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Татварын ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Татварын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 оноос хойш холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль, журам мөрдөгдөхгүй байх зэрэг үр дагавартай байна.

Татварын ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Татварын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 13 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 39,992.0 сая төгрөгийн 2 хувь буюу 799.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 33 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 31 санхүүгийн тайланг аудитад хамруулж, 2 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 28 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Багахангай дүүргийн татварын хэлтсийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, Татварын ерөнхий газар, Улсын төсвийн орлого хяналтын газрын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,139.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,423.6 сая төгрөгийн 40 алдааг аудитын явцад залруулж, 9.4 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 244.1 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 462.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 69 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн санхүүгийн байдлын тайлангийн дүн давхар татагдсанаас шалтгаалан 8.3 сая төгрөгөөр

бараа материалыг, 324.9 сая төгрөгөөр эргэлтийн бус хөрөнгийг, 333.2 сая төгрөгөөр цэвэр хөрөнгө өмчийн дүнг тус тус илүү нэгтгэсэн;

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 47.6 сая төгрөгөөр туслах үйл ажиллагааны, 910.0 сая төгрөгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан, нэмэлт санхүүжилтийн 17.6 сая нийт 957.2 сая төгрөгөөр орлогыг илүү, 18.4 сая төгрөгөөр бараа үйлчилгээний, 46.8 сая төгрөгөөр төвлөрүүлэх шилжүүлгийг, 910.0 сая төгрөгөөр үйл ажиллагааны бус нийт 957.2 сая төгрөгөөр зардлыг илүү нэгтгэсэн;

- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 47.6 сая төгрөгөөр туслах үйл ажиллагааны, 41.7 сая төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн нийт 89.3 сая төгрөгөөр орлогыг илүү, 69.3 сая төгрөгөөр урсга, 20.0 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтын нийт 89.3 сая төгрөгөөр зардлыг илүү нэгтгэсэн;

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

Цайны газрын 26.8 сая төгрөгийн агааржуулалтын төхөөрөмж хийж суурилуулах ажил, барилгын засвар, заслын 69.5 сая төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг тус тусад харьцуулалтын аргаар зохион байгуулж нэг компаниар гүйцэтгүүлсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 276.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 4 зөвлөмж өгснийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,369.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,025.8 сая төгрөгийн 36 алдааг аудитын явцад залруулж, 9.4 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 147.8 сая төгрөгийн 13 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 186.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 65 зөвлөмжийг хүргүүлээ.

Харьяа байгууллагуудад 9.4 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах 6 акт тогтоосон байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт: Түлээ нүүрсний хөнгөлөлтөөс НДШ суутгаагүй, кассын тайлангийн эхний, эцсийн үлдэгдэл зөрүүтэй, хууль, журамд заагаагүй төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн, ХХОАТ-ыг илүү суутгасан, шатахууны зарцуулалт баримтаар нотлогдоогүй, дараа тооцоогоор ажилчдаас суутгах хувцасны үнийг суутгаагүй, тэтгэмж, амралтын цалин илүү олгосон, тушаалд нэр нь ороогүй ажилтанд шагнал олгосон. /Дорноговь 0.1 сая, Дорнод 0.7 сая, Завхан 2.5 сая, Орхон 0.4 сая, Төв аймаг 0.5 сая, Налайх дүүрэг 5.2 сая төгрөг/

Харьяа байгууллагуудад 147.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 13 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт: Аймгийн Засаг даргын албан бичгийг үндэслэн урамшуулал авсан, хөдөлмөрийн дотоод журамд заагаагүй тэтгэмж олгосон, түлээ нүүрсний хөнгөлөлтийг төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдардаг ажилтанд олгосон, албан томилолтын хуудасгүй томилолтын нөхөн олговор олгосон, амралтын цалин буруу тооцоолж олгосон, эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулалт гаргасан, бараа материал үндсэн хөрөнгийн тооллого, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулаагүй байна. /Дорноговь 2.1 сая, Дундговь 4.4 сая, Сэлэнгэ 2.2 сая, Дорнод 1.7 сая, Говьсүмбэр 1.6 сая, Орхон 54.6 сая, Говь-Алтай 1.3 сая, Баян-Өлгий 1.5 сая, Чинээлтэй 6.1 сая, Сонгинохайрхан 23.8 сая Багахангай 48.5 сая төгрөг/

2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 865.8 сая, эцсийн үлдэгдэл 37.9 сая төгрөг болж, 827.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	865.8	37.9	-827.9
Дүн	865.8	37.9	-827.9

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 19.8 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд, 18.1 сая төгрөг ахмадын сангийн дансанд, 1.7 мянган төгрөг мөнгөн кассын дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт: Барьцаа хөрөнгийг өглөгөөр бүртгээгүй, и-баримтгүй болон анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан нийт 61.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Татварын ерөнхий газрын барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа 5.1 сая төгрөгийг өглөгөөр бүртгээгүй,
- И-баримтгүй болон зөрүүтэй дүнтэй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан /*Чингэлтэй, Сонгинохайрхан, Багахангай 21.9 сая, Төв аймаг 26.0 сая төгрөг/*
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар 8.5 сая төгрөгийн ажил гүйлгээг хийсэн. /*Хан-Уул 0.9 сая, Нийслэл 0.8 сая, Чингэлтэй 0.1 сая, Сонгинохайрхан 3.1 сая, Сүхбаатар 0.6 сая, Налайх 2.6 сая, Багахангай 0.3 сая төгрөг/*

2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,791.1 сая, эцсийн үлдэгдэл 230.1 сая төгрөг болж, 1,561.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	2.9		-2.9
Бусад авлага	1,788.2	230.1	-1,558.1
Дүн	1,791.1	230.1	-1,561.0

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд Татварын ерөнхий газрын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлснээс үүсэн 205.1 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Дампуурсан арилжааны банкнуудтай холбоотой 5.3 сая төгрөгийн авлага байна. /*Архангай аймаг Ардын банк 0.6 сая, Орхон аймаг Сэргээн босголт банк 1.1 сая, Сонгинохайрхан Сэргээн болголт банк 2.2 сая, Хөвсгөл аймаг Сэргээн босголт банк 1.4 сая төгрөг/*

Сангийн яамнаас авах 2013-2014 онд үүссэн 2.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. /*Хан-Уул дүүрэг 1.1 сая, Увс 0.6 сая, Хөвсгөл 0.6 сая төгрөг, бусад 5 аймаг 33.3 мянган төгрөг байна /*

Ажлаас гарсан ажилтантай холбоотой 1.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. /*Багахангай 0.2 сая, Нийслэл 0.6 сая, Татварын ерөнхий газар 0.2 сая төгрөг/*

2.9.3 УРЬДЧИЛЖ ГАРСАН ЗАРДАЛ

Хүснэгт №3 Урьдчилж гарсан зардлын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	49.2	847.7	798.5
Дүн	49.2	847.7	798.5

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны эцсийн үлдэгдэлд Татварын ерөнхий газар Би Жи Эйч ХХК-тай 2019 оны 12 сард байгуулсан Татварын улсын байцаагчийн ажлын хувцас үйлдвэрлэн нийлүүлэх гэрээний дагуу 830.3 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагын Чингис Хаан банкны урьдчилгаа төлбөрийн баталгаагаар шилжүүснээс үүссэн төлбөрийг бүртгэсэн байна.

2.9.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1,862.4 сая, эцсийн үлдэгдэл 1,347.2 сая төгрөг болж, 515.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	0.5	0.7	0.2
Дуусаагүй үйлдвэрлэл	650.0		-650.0
Бэлэн бүтээгдэхүүн	32.9	65.7	32.8
Хангамжийн материал	1,174.1	1,275.9	101.8
Мал амьтад	4.9	4.9	0.0
Дүн	1,862.4	1,347.2	-515.2

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 515.2 сая төгрөгөөр өмнөх оноос буурахад Татварын ерөнхий газрын бараа материал 565.3 сая төгрөгөөр өсөж, Ховд аймгийн Татварын хэлтсийн дуусаагүй үйлдвэрлэлийн 650.0 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материалыг бөөн дүнгээр зарлагдсан, шууд зардалд бүртгэсэн, дансны ангилал буруу бүртгэсэн, жилийн эцсийн тооллого хийгээгүй /Ховд аймаг 5.1 сая, Баянгол 3.3 сая, Сүхбаатар 11.4 сая, Багахангай дүүрэг 19.5 сая төгрөг/

Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс 21.2 сая төгрөгийн худалдан авалтад хийхдээ гэрээ байгуулсан.

Шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, жишиг нормоос илүү зарцуулсан /Чингэлтэй 0.3 сая, Сонгинохайрхан 1.2 сая, Налайх дүүрэг 4.8 сая, Орхон 2.1 сая, Дорнод аймаг 0.7 сая, төгрөг /

2.9.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 22,730.1 сая, эцсийн үлдэгдэл 21,717.8 сая төгрөг болж, 1,012.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	14,359.3	15,268.7	909.4

Авто тээврийн хэрэгсэл	1,070.9	1,896.2	825.3
Машин тоног төхөөрөмж	1,815.4	1,488.7	-326.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,025.9	1,019.0	-6.9
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	0.1	0.1	0.0
Бусад хөрөнгө	122.0	105.1	-16.9
Ном	5.9	3.4	-2.5
Үндсэн хөрөнгийн дүн	18,399.6	19,781.2	1,381.7
Программ хангамж	2,129.0	1,774.5	-354.5
Бусад биет бус хөрөнгө	1,189.3	1,174.4	-14.9
Биет бус хөрөнгийн дүн	3,318.3	2,948.9	-369.4
Дүн	21,717.8	22,730.1	1,012.3

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,805.4 сая, үнэ төлбөргүй, хандиваар авсан 2,692.3 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба балансаас балансад шилжүүлсэн 72.9 сая, акталсан 1,100.8 сая, харьяа байгууллага хооронд шилжүүлсэн 794.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Жилийн эцсийн тооллогыг хангалтгүй зохион байгуулсан, үндсэн хөрөнгө бодитоор оршин байгаагүй, хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэсэн, акталсан хөрөнгийн устгал хийгээгүй, үндсэн хөрөнгийн карт хөтлөөгүй нийт 59.9 сая төгрөг /Баянгол 2.4 сая, Баянзүрх 4.8 сая, Чингэлтэй 23.9 сая, Багахангай 28.8 сая төгрөг/

2.9.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,227.7 сая, эцсийн үлдэгдэл 20.4 сая төгрөг болж, 2,207.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ажиллагсадтай холбогдсон өглөг	0.6	1.6	1.0
Байгууллагад өгөх өглөг	1,377.6	18.8	-1,358.8
Хувь хүмүүст өгөх өглөг	845.4		-845.4
Бусад өглөг	4.1		-4.1
Нийт дүн	2,227.7	20.4	-2,207.3

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 16.9 сая төгрөгийн барьцаа, 1.6 сая төгрөгийн ажиллагсадтай холбогдсон өр байна.

Аудитын илрүүлэлт:

Багахангай дүүргийн татварын хэлтэс өглөгийг илүү, дутуу тайлагнасан, илүү төлөлтийг өглөгөөр тайлагнасан, тулган баталгаажуулаагүй 2.0 сая төгрөгийн зөрчил байна.

2.9.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 35.5 сая, эцсийн үлдэгдэл 38.0 сая төгрөг болж, 2.4 сая төгрөгөөр байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,017.3	20,015.6	(1.74)	79.5
Хуримтлагдсан үр дүн	(76.7)	1,062.7	1,139.38	4.2
Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	4,118.1	4,135.5	17.39	16.4
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		(43.1)	(43.10)	(0.2)
Дүн	24,058.7	25,170.6	1,111.9	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд тайлант онд 7 аймгийн Татварын газар дахин үнэлсэн, хөрөнгө акталж устгасан 43.1 сая төгрөгийг тайлагнасан байна.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 42,011.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 39,261.5 сая төгрөгийг урсгал зардалд, 2,750.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 37,679.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 4,332.1 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 37,549.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 129.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Тайлант онд 4,332.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 4,055.8 сая төгрөгийг төвлөрүүлж 93.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт№ 8. Үйл ажиллагааны орлого /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	4,032.2	4,003.7	28.5	99.3
Туслах үйл ажиллагааны орлого	300.0	52.1	247.9	17.4
Нийт дүн	4,332.2	4,055.8	276.4	93.7

Орлогын төлөвлөгөө 276.4 сая төгрөгөөр тасарсан нь онцгой албан татварын тэмдэг үйлдвэрлэх, нийлүүлэхтэй холбоотой гэрээ дууссан, тэмдэгтийн загвар болон нууцлалын өөрчлөлтийг Сангийн сайдын тушаалаар баталгаажуулахтай холбоотой ажлууд хийгдэж 2 сар гаруй хугацаанд онцгой албан татварын тэмдэг үйлдвэрлэх, захиалах, нийлүүлэх үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 41,605.3 сая төгрөг гарч 99.9 хувийн биелэлттэй, 102.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 406.3 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь Татварын ерөнхий газрын өөрийн орлого 276.4 сая төгрөгөөр тасарснаас нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал 261.7 сая төгрөгийг зарцуулаагүй, цалин, нэмэгдэл, шимтгэлийн зардал 108.1 сая, хөрөнгө оруулалтыг гүйцэтгэлээр санхүүжүүлснээс 28.4 сая төгрөг тус тус хэмнэгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 2,750.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 2,721.6 сая төгрөгийн санхүүжилт олгосноос хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт 1,324.3 сая төгрөгийг Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Бид Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудитаар Сангийн сайдын тушаалаар зарцуулах эрх шилжүүлэн Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан

хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт 1,324.3 сая төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар үргэлжлүүлэн авч үзнэ.

Мөн Татварын ерөнхий газар Би Жи Эйч ХХК-тай 2019 оны 12 сард байгуулсан Татварын улсын байцаагчийн ажлын хувцас үйлдвэрлэн нийлүүлэх гэрээний дагуу 830.3 сая төгрөгийг гүйцэтгэгч байгууллагын Чингис Хаан банкны урьдчилгаа төлбөрийн баталгаагаар шилжүүлсэн гэрээт ажлын гүйцэтгэлийг дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгах.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Татварын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Мөн цалин, бараа материалтай холбоотой 38.3 сая төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 93.3 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Татварын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Татварын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 АВЛАГА, ӨГЛӨГИЙН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт:

- Харьяа газруудад 1996-2005 онуудад үүссэн дампуурсан арилжааны банкнуудтай холбоотой 5.3 сая төгрөгийн авлага, үнэт цаас болон дансны үлдэгдэл татан төвлөрүүлснээс 2013-2014 онд үүсэж тайланд онд ерөнхий газар Сангийн яамнаас нийт дүнгээр нь дансанд төвлөрүүлж тооцоогүй болсныг авлагаас хасаагүй 2.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;

- Барьцаа хөрөнгийн өглөгийг 5.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул, үнэн зөв, бодитой оршин байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудын 1996-2005 онуудад үүссэн дампуурсан арилжааны банкнуудтай холбоотой 5.3 сая, Сангийн яамтай холбоотой 2.3 сая төгрөгийн авлагыг холбогдох стандарт, хууль, журмын дагуу эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн данснаас хасах, барьцааны өглөг 5.1 сая төгрөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 Илрүүлэлт:

Татварын хуулиудын шинэчлэлийн талаарх сурталчилгаа нэвтрүүлэг, шторк түгээх ажил үйлчилгээний ажлын 609.6 сая төгрөгийн зарцуулалтаас гэрээ хийгээгүй төлбөр шилжүүлсэн 12.3 сая төгрөг, гэрээ дүгнэсэн актгүй олгосон 76.4 сая төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль, журам мөрдөгдөхгүй байх, төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээт ажлын гүйцэтгэлийг анхан шатны баримт болон холбогдох нотлох баримтын бүрдлийг хангаж бүртгэл тайланд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.3.1 Илрүүлэлт:

Татварын ерөнхий газрын даргын тушаалаар Төсвийн татварын орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэхэд идэвх чармайлт гаргасан гэх үндэслэлээр нэмэлт санхүүжилтийн орлогын эх үүсвэрээс Татварын ерөнхий газар, Улсын төсвийн орлого хяналтын газрын нийт албан хаагчдад нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний шагналд 174.9 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Төсвийг үр ашиггүй зарцуулах, хууль, тогтоомж биелэгдэхгүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Шагнал урамшуулал олгохдоо холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 ХАРЬЯА ГАЗУУДАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.4.1 Илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын аудитаар нийт 1,369.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,025.8 сая төгрөгийн 36 алдааг аудитын явцад залруулж, 9.4 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 147.8 сая төгрөгийн 13 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 186.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 65 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.4.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,568,693.5	3,787,261.2
МӨНГӨН ХӨРӨНГӨ	865,844.3	37,949.2
АВЛАГА	1,791,157.3	230,151.6
УРЬДЧИЛГАА	49,259.3	847,669.0
БАРАА МАТЕРИАЛ	1,862,432.6	1,347,192.8
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	1,324,298.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	21,717,770.2	22,730,159.1
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	21,717,770.2	22,730,159.1
Биет хөрөнгө	18,399,615.1	19,781,238.9
Биет бус хөрөнгө	3,318,155.1	2,948,920.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	26,286,463.7	26,517,420.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,227,695.7	20,396.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,227,695.7	20,396.8
Өглөг	2,227,695.7	20,396.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,058,768.0	26,497,023.4
Засгийн газрын хувь оролцоо	24,058,768.0	26,497,023.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,017,342.1	20,015,564.2
Хуримтлагдсан үр дүн	-76,692.0	2,345,945.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,118,117.9	4,135,513.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	26,286,463.7	26,517,420.3

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	41,604,435.3	41,722,081.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,570,366.1	4,766,199.0
Нийтлэг татварын бус орлого	5,570,366.1	4,766,199.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,034,069.2	36,955,882.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	40,109,218.6	38,911,538.9
УРСГАЛ ЗАРДАЛ	39,915,369.4	38,911,538.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,695,999.7	36,512,984.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,361,291.5	24,367,031.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,667,650.0	3,058,958.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,286,921.6	1,404,156.9
Хангамж, бараа материалын зардал	996,704.0	1,246,956.8
Нормативт зардал	2,577.6	75,635.1
Эд хогшил, урсгал засварын зардал	186,429.1	492,316.1
Томилолт, зочны зардал	199,458.0	265,028.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,501,932.8	2,646,216.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,493,035.1	2,956,685.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,219,369.7	2,398,554.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	193,849.2	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,495,216.7	2,810,542.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	10,768.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,065,322.5	105,398.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	429,894.2	2,715,912.8

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	139,042,341.7	183,723,138.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,423,434.0	4,091,178.6
Нийтлэг татварын бус орлого	4,423,434.0	4,091,178.6
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	134,618,907.7	179,631,959.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,677,233.8	182,987,481.0
УРСГАЛ ЗАРДАЛ	135,677,233.8	182,987,481.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,507,025.5	39,080,263.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,305,859.9	24,267,700.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,648,143.5	3,134,788.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,293,778.1	1,402,914.6
Хангамж, бараа материалын зардал	979,897.9	1,002,030.6
Нормативт зардал	63,612.1	960,247.6
Эд хогшил, урсгал засварын зардал	352,459.4	603,256.5
Томилолт, зочны зардал	204,271.5	275,529.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,070,956.5	6,503,909.1
Бараа үйлчилгээний бусад зардал	588,046.6	929,886.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,170,208.3	143,907,217.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,365,107.9	735,657.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,024,941.9	1,563,552.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,024,941.9	1,563,552.2
Дотоод эх үүсвэрээр	3,024,941.9	1,563,552.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,024,941.9	-1,563,552.2
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	340,166.0	-827,895.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	525,678.4	865,844.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	865,844.4	37,949.2

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,472,803.3	0.0	20,472,803.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	171,325.6	0.0	171,325.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,644,128.9	0.0	20,644,128.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,939,154.1	0.0	1,939,154.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,045,590.9	0.0	1,045,590.9
Тайлант үеийн үр дүн	429,894.2	0.0	429,894.2
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,058,768.0	0.0	24,058,768.0
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	24,058,768.0		24,58,768.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-295,053.1	0.0	-295,053.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,763,715.0	0.0	23,763,715.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	17,395.7	0.0	17,395.7
Тайлант үеийн үр дүн	2,715,912.8	0.0	2,715,912.8
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,497,023.4	0.0	26,497,023.4

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,011,548.7	41,605,295.4	406,253.4	99.0
УРСГАЛ ЗАРДАЛ	39,261,548.7	38,883,728.0	377,820.7	99.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,258,445.7	36,881,601.4	376,844.3	99.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,676,736.8	23,578,630.9	98,105.9	99.6
Үндсэн цалин	14,679,248.9	15,367,330.4	-688,081.5	104.7
Нэмэгдэл	5,145,509.1	4,450,247.4	695,261.7	86.5
Унаа хоолны хөнгөлөлт	1,506,742.5	1,400,038.2	106,704.3	92.9
Урамшуулал	2,345,236.3	2,361,014.9	-15,778.6	100.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,079,353.8	3,069,334.6	10,019.2	99.7
Тэтгэврийн даатгал	2,106,760.5	2,220,905.7	-114,145.2	105.4
Тэтгэмжийн даатгал	243,148.5	238,488.6	4,659.9	98.1
ҮОМШӨ-ний даатгал	194,518.7	167,065.2	27,453.5	85.9
Ажилгүйдлийн даатгал	48,629.6	49,799.5	-1,169.9	102.4
Эрүүл мэндийн даатгал	486,296.5	393,075.7	93,220.8	80.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,402,194.7	1,399,914.6	2,280.1	99.8
Гэрэл, цахилгаан	181,340.0	186,042.1	-4,702.1	102.6
Түлш, халаалт	501,764.3	495,290.0	6,474.3	98.7
Цэвэр, бохир ус	62,716.2	63,855.5	-1,139.3	101.8
Байрны түрээс	656,374.2	654,727.1	1,647.1	99.7
Хангамж, бараа материалын зардал	891,128.8	890,137.6	991.2	99.9
Бичиг хэрэг	216,707.3	235,819.1	-19,111.8	108.8
Тээвэр, шатахуун	200,128.5	198,993.9	1,134.6	99.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	293,817.8	278,018.8	15,799.0	94.6
Ном, хэвлэл	20,098.4	17,894.7	2,203.7	89.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24,651.5	18,610.2	6,041.3	75.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	135,725.3	140,800.9	-5,075.6	103.7
Нормативт зардал	1,201,236.2	939,542.6	261,693.6	78.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000.0	2,000.0	0.0	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,199,236.2	937,542.6	261,693.6	78.2
Эд хогшил, урсгал засварын зардал	409,762.5	409,433.0	329.5	99.9
Багаж, техник, хэрэгсэл	104,691.8	104,271.8	420.0	99.6
Тавилга	6,023.7	6,023.7	0.0	100.0
Урсгал засвар	299,047.0	299,137.4	-90.4	100.0
Томилолт, зочны зардал	239,487.2	237,963.4	1,523.8	99.4
Гадаад албан томилолт	7,426.9	7,426.9	0.0	100.0
Дотоод албан томилолт	180,495.8	178,972.1	1,523.7	99.2
Зочин төлөөлөгч хүлээн авах	51,564.5	51,564.4	0.1	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,777,653.5	5,775,848.7	1,804.8	100.0

Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,806,551.6	1,805,103.8	1,447.8	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,128.3	7,106.3	22.0	99.7
Даатгалын үйлчилгээ	33,015.9	32,970.1	45.8	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	3,558.4	3,501.1	57.3	98.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,784.9	1,663.2	121.7	93.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,402.5	582,334.3	68.2	100.0
Газрын төлбөр	3,211.9	3,169.9	42.0	98.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,340,000.0	3,340,000.0	0.0	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	580,892.2	580,796.1	96.1	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	21,381.3	21,381.2	0.1	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	559,510.9	559,414.9	96.0	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,003,103.0	2,002,126.6	976.4	100.0
Бусад урсгал шилжүүлэг	2,003,103.0	2,002,126.6	976.4	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	379,301.8	378,740.8	561.0	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,499,201.2	1,499,196.2	5.0	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	124,600.0	124,189.6	410.4	99.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,750,000.0	2,721,567.3	28,432.7	99.0
Барилга байгууламж	2,750,000.0	2,721,567.3	28,432.7	99.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,011,548.7	41,605,295.3	406,225.5	99.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,679,364.7	37,549,523.6	129,841.1	99.7
Улсын төсвөөс санхүүжих	37,679,364.7	37,549,523.6	129,841.1	99.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,332,184.0	4,055,771.8	276,384.3	93.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,032,184.0	4,003,704.8	28,479.2	99.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.0	52,094.9	247,905.1	17.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		865,844.3	-865,844.30	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		37,949.2	-37,949.20	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,823	1,823	0.00	100
Удирдах ажилтан	37	37	0	100
Гүйцэтгэх ажилтан	1,653	1,653	0.00	100
Үйлчлэх ажилтан	133	133	0	100
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,823	1,823	0.00	100
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,430	1,430	0.00	100
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	393	393	0	100

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,323,429.7
УРСГАЛ ЗАРДАЛ	4,155,585.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,625,798.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	689,069.4
Үндсэн цалин	648,302.3
Унаа хоолны хөнгөлөлт	26,117.9
Урамшуулал	14,450.1
Гэрээт ажлын хөлс	199.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,454.2
Тэтгэврийн даатгал	65,393.4
Тэтгэмжийн даатгал	51.2
ҮОМШӨ-ний даатгал	2.6
Ажилгүйдлийн даатгал	0.6
Эрүүл мэндийн даатгал	6.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,000.0
Байрны түрээс	3,000.0
Хангамж, бараа материалын зардал	115,863.3
Бичиг хэрэг	60,293.9
Тээвэр, шатахуун	19,713.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,009.7
Ном, хэвлэл	10,424.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,422.6
Нормативт зардал	20,705.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,705.0
Эд хогшил, урсгал засварын зардал	305,528.9
Багаж, техник, хэрэгсэл	11,145.7
Тавилга	12,000.0
Урсгал засвар	282,383.2
Томилолт, зочны зардал	37,566.4
Дотоод албан томилолт	37,566.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,026,807.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,339,744.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,000.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	164.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	677,899.2
Бараа үйлчилгээний бусад зардал	361,804.0
Бараа үйлчилгээний бусад зардал	174,922.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	186,881.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	529,786.5
Бусад урсгал шилжүүлэг	291,691.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,220.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,200.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	232,271.5
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	238,095.0
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	231,862.9

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	167,844.5
Дотоод эх үүсвэрээр	167,844.5
Тоног төхөөрөмж	64,000.0
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	103,844.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,323,268.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	4,323,268.0
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,232.1
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,169,799.0
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	840,527.3
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,305,709.6
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-161.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	161.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.2

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.20	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/01/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Татварын ерөнхий газрын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж нийт 1,956.5 сая төгрөгийн зарцуулалтаас татварын хуулиудын шинэчлэлийн талаар сурталчилгаа нэвтрүүлэг, шторк түгээх ажил үйлчилгээний гэрээт ажлын төлбөр 95 харилцагч байгууллагатай байгуулсан 609.6 сая төгрөгийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад гэрээ хийгээгүй төлбөр шилжүүлсэн 12.3 сая төгрөг, гэрээ дүгнэсэн актгүй 76.4 сая төгрөг, э-баримтгүй 461.8 сая төгрөг байна.	88.8	Зөвлөмж өгөх		
2	Харьяа газруудад 1996-2005 онуудад үүссэн дампуурсан арилжааны банкнуудтай холбоотой 5.3 сая төгрөгийн авлага, үнэт цаас болон дансны үлдэгдэл татан төвлөрүүлснээс 2013-2014 онд үүсэж тайланд онд ерөнхий газар Сангийн яамнаас нийт дүнгээр нь дансанд төвлөрүүлж тооцоогүй болсныг авлагаас хасаагүй 2.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Барьцаа хөрөнгийн харилцах данс 19.8 сая төгрөг, барьцаа хөрөнгийн өглөг 14.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж 5.1 сая төгрөгөөр харилцах дансны үлдэгдэл илүү байна.	12.8	Зөвлөмж өгөх	ТЕГ-ын дарга Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Заяабал Л.Бямбадорж Ж.Гэрэлбат
3	Цайны газрын 26.8 сая төгрөгийн агааржуулалтын төхөөрөмж хийж суурилуулах ажил, барилгын засвар, заслын ажил 69.5 сая төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг тус тусад харьцуулалтын аргаар зохион байгуулж нэг компаниар гүйцэтгүүлсэн байна.	96.3	Албан шаардлага өгөх		

4	Татварын ерөнхий газрын даргын тушаалаар Төсвийн татварын орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэхэд идэвх чармайлт гаргасан гэх үндэслэлээр нэмэлт санхүүжилтийн орлогын эх үүсвэрээс Татварын ерөнхий газар, Улсын төсвийн орлого хяналтын газрын нийт албан хаагчидад нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний шагналд 174.9 сая төгрөгийг зарцуулсан байна.	174.9	Зөвлөмж өгөх		
5	Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын аудитаар нийт 1,369.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,025.8 сая төгрөгийн 36 алдааг аудитын явцад залруулж, 9.4 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 147.8 сая төгрөгийн 13 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 186.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 65 зөвлөмж өгсөн байна		Зөвлөмж өгөх		
Нийт дүн		372.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/194

Улаанбаатар хот

САГ- 2020/01/СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу Татварын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Цайны газрын 26.8 сая төгрөгийн агааржуулалтын төхөөрөмж хийж суурилуулах ажил, засвар, заслын 69.5 сая төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг тус тусад нь харьцуулалтын аргаар зохион байгуулж нэг компаниар гүйцэтгүүлсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 09 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Бямбадорж нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

 Б.СЭРЖМЯДАГ

АУДИТОР

 А.ДАВААДОРЖ

ЗӨВШӨӨРСӨН:

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА

 Б.ЗАЯАБАЛ

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Л.БЯМБАДОРЖ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.